

## Хяналт шалгалт хийсэн тухай

### **Нэг. Шалгалтын зорилго:**

Сангийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн № СХШХ/06 тоот удирдамжийн дагуу Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны даргын баталсан 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 36 тоот удирдамжийн хүрээнд 2020-2021 онуудад төрөөс айл өрх, аж ахуй нэгжид цахилгаан, дулаан, уур усны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой үйлчилгээ үзүүлсэн аж ахуй нэгжийн хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн тооцоонд Төрийн хяналт шалгалтын тухай, Төсвийн тухай, Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоол болон бусад холбогдох тогтоомж дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, дүгнэлт гаргахад хяналт шалгалтын зорилго чиглэгдэв.

### **Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн хугацаа:**

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Т.Цэрэгбаяр ахалж, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Д.Оюунсүрэн, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор Б.Чулуунбат нар 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс ажлын 20 хоногт хийж гүйцэтгэлээ.

### **Гурав. Шалгалтад хамрагдсан асуудлууд:**

Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолд заасан нөхцөлөөр төрөөс хөнгөлөлт эдэлсэн айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хамрагдалт хангасан эсэх

Цахилгаан, дулаан, уур усны үнийн хөнгөлөлт үзүүлсэн аж ахуйн нэгжийн хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн тооцоо;

Нийт нэхэмжилсэн цахилгаан, дулаан, уур, ус, хогны биет хэмжээ, үнийн дүн  
Улсын төсвөөс цахилгаан, дулаан, уур, ус, хогны үнийн хөнгөлөлтөд төлсөн нийт төлбөрийн хэмжээ

### **Дөрөв. Шалгалтад хамрагдсан объектуудын талаарх товч мэдээлэл:**

ДБЭХС ТӨҮГ-ын Сүхбаатар салбар, Дөрвөлж ОНӨААТҮГ, Сүхбаатар Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ, Түмэнцогт Ус Дулаан ОНӨААТҮГ, Дарьганга Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ, Хайлааст-Голомт ОНӨААТҮГ, Чоногол-Хөгжил ОНӨААТҮГ, Онгон-Аривжих ОНӨААТҮГ, Халзан Дулаан ОНӨААТҮГ газар Сумдын нэмэлт санхүүжилтийн данс /ус, хогны хөнгөлөлт, чөлөөлөлт/ төлбөр тооцоо хамрагдсан.

**Тав. Өмнөх шалгалтын талаар:**

Эрчим хүчний сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/47 мөн 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/159 тоот тушаалуудаар Засгийн газрын 2020 оны 211 тоот тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг хяналт хийж, Эрчим хүчний сайдын 2021 оны А/2286 тоот албан бичгээр 5 санал зөвлөмж өгснийг ханган ажилласан байна.

**Зургаа. Шалгалтын явцад хийгдсэн ажил:**

Сангийн сайдын баталсан 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн СХШХ/06 дугаар удирдамжийн дагуу албаны даргын баталсан удирдамжийг Сүхбаатар аймгийн холбогдох аж ахуй нэгжүүд, сумдын Засаг дарга нарт цахимаар хүргүүлэв.

Мөн шалгалтад хамрагдах төрийн болон орон нутгийн өмчит 20 байгууллагын хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэх санхүүжилтийн тооцооны баримтыг хамруулсан.

*Цахилгааны хөнгөлөлтийн талаар:*

ДБЭХС ТӨҮГ-ын Сүхбаатар салбар нь Засгийн газрын хөнгөлөлттэй холбоотойгоор 2021 оны байдлаар 105 ширхэг өргөдөл гомдол ирсэн бөгөөд эдгээр өргөдөл гомдлыг 100 хувь шийдвэрлэсэн байна. 2021 онд өөрийн байрны халаалтыг цахилгаанаар шийдвэрлэсэн айл өрхөөс өргөдөл, иргэний үнэмлэхийн хуулбар, халаалтын системийн зураг, ААНБ-ын гэрчилгээ, мөн байцаагч нарын үзлэг шалгалтыг үндэслэн өргөдлийг шийдвэрлэн сар бүр Дорнод салбарт мэдээлж ажилласан байна.

Тус салбарын хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэхийн тооцоо нь 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд давхардсан тоогоор 172630 айл өрхөд 3724479995 төгрөгийн, 6865 аж ахуй нэгж байгууллагад 1102051039 төгрөгийн, нийт 4826531034 төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлсэн байна.

*Дулааны хөнгөлөлтийн талаар:*

Халаалт дулааны үйл ажиллагаа явуулдаг 7 байгууллагын хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэхийн тооцоо нь 2020 оны 12 дугаар

сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд 6155 айл өрхөд 1059887639 төгрөгийн, 605 аж ахуй нэгж байгууллагад 1258547282 төгрөгийн нийт 2318434921 төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлсэн байна.

*Усны хөнгөлөлтийн талаар:*

Усны тусгай зөвшөөрөлтэй 2 байгууллагын хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэхийн тооцоо нь 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд 34527 айл өрхөд 716481790 төгрөгийн, 344 аж ахуй нэгж байгууллагад 140206662 төгрөгийн нийт 856688452 төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлсэн байна.

*Усны хөнгөлөлтийн талаар:*

Хот тохижилт хариуцсан 5 байгууллагын хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэхийн тооцоо нь 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд давхардсан тоогоор 7900 айл өрх, 1141 аж ахуй нэгж байгууллага хамрагдаж 88200825 төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлсэн байна.

**Долоо. Шалгуулагчдын ололттой, дэвшилттэй тал:**

ДБЭХС ТӨҮГ-ын Сүхбаатар салбар нь Монгол улсын Засгийн газрын 2020/12/13-ны 211 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор системд байгаа бүх хэрэглэгчдийг чөлөөлөлтөд хамрагдах болон үл хамрагдах ангилал тус бүрээр ялган хуваарилах ажлыг цаг алдалгүй хийж, системийн 1200 гаруй аж ахуйн нэгж байгууллагын код бүрийн дэд ангилал, үнэ тарифын сонголтыг шалган сайжруулж хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэхэд алдаа дутагдал гарахгүй байх боломжийг бүрдүүлэн ажилсан байна.

Дөрвөлж ОНӨАТҮГ нь төрөөс хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэхтэй холбогдуулан хэрэглэгчийн үлдэгдлийн болон тоолуурын заалтын баталгаанд үзлэг шалгалт хийх болон хэрэглэгчийн өмнөх авлага барагдуулах ажлыг зохион байгуулсны үр дүнд хувь хэрэглэгчийн авлага 146.3 – 33.5 сая буюу 77.2 хувиар аж ахуй нэгжийн авлага 264.8- 45.8 сая буюу 82.7 хувиар буурсан байна

**Найм. Шалгалтаар илрүүлсэн нийтлэг зөрчил, дутагдал, шалтгаан түүнээс гарч болзошгүй буюу гарсан хохирол, хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт:**

1.Баяндэлгэр сумын Төрийн банкны салбар нь 2020 оноос Наран соёмбо ХХК-ын, Баруун-Урт сумын төрийн банкны Өгөөмөр салбар нь Монос ХХК-ын өмчлөлийн байранд, Баруун-Урт сумын Таван-Эрдэнэ ХХК-ны худалдаа үйлчилгээний төвийн байранд Гялс төгрөг ББСБ, үүрэн холбооны Мобиком ХХК,

Жи мобайл ХХК-ны салбарууд тус тус үйл ажиллагаагаа явуулдаг ба байр ашиглалт /Цахилгаан, хог, ус, дулаан/-ын зардал төлдөггүй зардлыг түрээслүүлэгч тал бүрэн хариуцахаар түрээсийн гэрээ хийсэн ба дээрх байгууллагууд нь Засгийн газрын хөнгөлөлт, чөлөөлөлтөд бүрэн хамрагдсан нь Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт /Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан төлөх"... 1.4. банк, банк бус санхүүгийн байгууллага, 1.7. интернэт, үүрэн холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч;/ гэж заасантай нийцэхгүй байна.

2.Байгаль орчин аялал жуучлалын Яамнаас олгосон айл өрх аж ахуй нэгж байгууллагын хог хаягдлын төлбөр чөлөөлөлтийн 88200825 төгрөгийн санхүүжилт нь аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжин олгогдсон бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс хойж 16020300 төгрөгийн санхүүжилт олгогдсон тул жилийн эцсээр 3 байгууллагад өглөг үүсгэн 2022 оны 3 дугаар сард төлбөрийг барагдуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9.аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Ес. Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал:**

Дээр дурдсан аж ахуйн нэгж байгууллагууд нь байр ашиглалт /Цахилгаан, хог, ус, дулаан/-ын зардлыг түрээслүүлэгч тал бүрэн хариуцахаар түрээсийн гэрээ хийж 2021 оны түрээсийн төлбөрт өөрчлөлт ороогүй бөгөөд түрээслүүлэгчид өмнөх оны мөн үеийн хэрэглээнээс давсан төлбөрөө тогтмол төлсөн байх тул акт тогтоох шаардлагагүй боловч хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэхийн тооцоонд анхаарах, байгууллагын ангилал, үнэ тарифын сонголтыг сайжруулах төсөв хөрөнгийг зохистой удирдах талаар зөвлөмж өгсөн болно.

**Арав. Шалгагдсан аж ахуйн нэгжид өгсөн дүгнэлт, шийдвэрлэвэл зохих асуудал:**

Эрчим хүч, уур ус, дулааны тусгай зөвшөөрөлтэй болон хот тохижуулалт хариуцсан байгууллагууд нь айл өрх, аж ахуй нэгжид цахилгаан, дулаан, уур усны үнийн хөнгөлөлт чөлөөлөлтийн үйлчилгээг Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын хүрээнд үнэн зөв хангалттай түвшинд хэрэгжүүлэн ажилласан байна.

**Арван нэг. Цаашид авах арга хэмжээний санал:**

Жил тутам дулаан, цахилгаан эрчим хүч нэмэгдэж байгаатай холбогдуулан хэрэглэгчийн ангилал, үнэ тарифын сонголт, дундаж хэрэглээ, тоолуур хэмжилтийг шалган сайжруулж, дулаан эрчим хүчний хэмнэлтийг бий болгох.

**ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН :**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОР

Т.ЦЭРЭГБАЯР

**ТАНИЛЦАЖ, ХЯНАСАН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э. АМАРБАТ